



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны сарын-ний
өдөр

Улаанбаатар хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

Төсөл
2019.06.25

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд тулгуурлан бүс нутгийн хөгжлийн оновчтой бүтэц бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах таатай нөхцлийг хангасан, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлсэн, хот, тосгоныг төлөвлөх, барьж байгуулахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хууль тогтоомж

2.1.Хот байгуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Хот, тосгоныг дахин хөгжүүлэх үйл ажиллагааг тухайлсан хуулиар зохицуулна.

2.3.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хот төлөвлөлт” гэж тухайн хот, тосгоны ирээдүйн хөгжил, эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн зөв зохистой үйлчилгээг бий болгохын тулд газар ашиглалт, хотын барилгажилт болон хот байгуулалтын тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн үе шат бүхий төлөвлөлтийн мэргэжлийн үйл ажиллагааг;

3.1.2.“хот байгуулалт” гэж түүх, соёл иргэншлийн уламжлал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, ашиглалт үйлчилгээ явуулах цогцолбор үйл ажиллагааг;

3.1.3.“хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” гэж хот, тосгоны харьцангуй бие дааж хөгжих нөхцлийг бүрдүүлсэн, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн, хот байгуулалтын баримт бичгийг;

3.1.4.“хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” гэж хот, тосгоны тухайн газар нутгийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг, зориулалтын дагуу хөгжүүлэхэд шаардлагатай газар зохион байгуулалт, барилгажилт, тохижилтын төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний хангамжийг нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичгийг;

3.1.5.“хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” гэж тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хүн амыг зөв зохистой нутагшуулан суурьшуулах зорилгоор нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргааны түвшин, байгалийн нөхцөл, нөөц, цаг уур, инженерийн дэд бүтцийн хангамж зэргийг тооцоолон хот, хөдөөгийн нутагшилт, суурьшилд тохиромжтой нутаг дэвсгэр, бүсүүдийг амралт, аялал жуулчлал, байгаль хамгаалал, түүх, соёлын асуудалтай уялдуулан тогтоохтой холбоотой судалгаанд суурилсан , төлөвлөлтийн баримт бичгийг;

3.1.6.“хот байгуулалтын баримт бичиг” гэж энэ хуульд заасан нутаг дэвсгэрийг болон хот, тосгоныг төлөвлөн хөгжүүлэхээр боловсруулсан зураглалын, тайлбар бичгийн бүрдэл бүхий баримт бичиг, тэдгээрийн суурь судалгааг;

3.1.7.“хот төлөвлөлтийн мэргэжилтэн” гэж архитектор, хот төлөвлөгч, хот төлөвлөлтийн эдийн засагч, бүс нутаг судлаач, ландшафтын архитектор мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй, хот төлөвлөлтийн чиглэлээр 5 доошгүй жил мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн мэргэжилтнийг;

3.1.8.“мэргэшсэн хот төлөвлөгч” гэж хот төлөвлөлтийн чиглэлээр зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй хот төлөвлөлтийн мэргэжилтнийг;

3.1.9.“мэргэжлийн байгууллага” гэж хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийг;

3.1.10.“бүс нутаг, хот төлөвлөлтийн институт” гэж шинжлэх ухаан, технологийн хөгжил, хот байгуулалтын олон улсын хөгжлийн чиг хандлага, төрийн бодлогын хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний ажил явуулах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлого боловсруулах, салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох, нийслэл хот, бүсийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, онцгой зохицуулалттай объектуудын зураг төсөл боловсруулах чиг үүрэг бүхий төрийн өмчийн үйлдвэрийн газрыг ;

3.1.11.“бүсчлэл” гэж хот, тосгоны нутаг дэвсгэрийг төлөвлөлтийн үе шатанд ашиглалтын төрөл, үүрэг, зориулалтаар бүсчлэн тодорхойлж, ашиглалтын хязгаарлалт тогтоон хөгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагааны горимыг хэлбэрийг;

3.1.12.“газар ашиглалтын бүсчлэл” гэж газар ашиглалтын бүсүүд ба түүнд харгалзах горимыг тодорхойлох зорилготой хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийг;

3.1.14.“давхцал бүс” гэж хотын түүх, соёлын зэрэг архитектурын ач холбогдол бүхий газар нутаг, хөшөө дурсгалыг хадгалах, хамгаалах зорилгоор тухайлсан ерөнхий төлөвлөгөө боловсруулан газар ашиглалтын бүсүүдэд нэмэлтээр давхцуулан тогтоосон бүсийг;

3.1.15.“газар нутгийг онцгой нөхцөлтэйгөөр ашиглах бүс” гэж хот, тосгоны нутаг дэвсгэрт хамаарах байгалийн өв болон түүх, соёлын зэрэг архитектурын дурсгалт барилга байгууламжийн хамгаалалтын бүс, усны болон ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс, улсын болон орон нутгийн хамгаалалтад орсон барилга байгууламжийн бүс болон хуулийн дагуу тогтоосон бусад бүсийг;

3.1.16.“нутаг дэвсгэрийн газар ашиглалтын бүсчлэлийн дүрэм” гэж газар ашиглалтын бүс болон хот байгуулалтын горим бүхий баримт бичгүүдийг хэрэглэх дэс

дараалал, дэг журмыг тогтоосон эрх бүхий байгууллагаас батлагдах газар ашиглалтын бүсчлэлийн баримт бичгийг;

3.1.18.“хот байгуулалтын норм ба дүрэм, журам” гэж хот байгуулалт, хот төлөвлөлтөд мөрдөх нийтлэг шаардлагын хэм хэмжээг тусгасан заавал дагаж мөрдөх техникийн норматив баримт бичгийг;

3.1.19.“хот байгуулалтын кадастр” гэж нутаг дэвсгэрийн ашиглалт, хүрээлэн буй орчны төлөв байдлын үнэлгээ, инженерийн шугам сүлжээний хангамжийн түвшин, барилга байгууламж, хүн амын амьдрах орчны чанарын тухай байр зүйн зураглал, мэдээллийн нэгдмэл санг;

3.1.20.“хот байгуулалтын техникийн нөхцөл” гэж хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, барьж байгуулахад шаардагдах дэд бүтцийн эх үүсвэр, технологийн шийдлийг мэргэжлийн байгууллагуудаас авах зөвшөөрлийг;

3.1.21.“хот байгуулалтын төсөл” гэж хот, тосгоныг бүрдүүлэхийн тулд хэрэгжүүлж буй хот байгуулалтын бүсэд орон сууц, аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ, мэдээлэл харилцаа, байгаль экологи, соёл, эрүүл мэнд болон нийгмийн хамгаалал зэрэг иж бүрдэл бүхий цогцолбор төсөл хөтөлбөрийг;

3.1.22.“хот байгуулалтын суурь нөхцөл” гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах үндэс болох байр зүйн зураглал, инженер геологийн дүгнэлт, газар хөдлөлийн бичил мужлалын зураглал, барилга, газар, дэд бүтэц, нийгэм эдийн засгийн иж бүрэн мэдээлэлийг,

3.1.23.“хот байгуулалтын мэдээллийн сан” гэж хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглуулахтай холбогдсон аймаг, нийслэлийн хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үндсэн хэрэглэгч, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах үйл ажиллагааг;

3.1.24.“хотын нутаг дэвсгэр” гэж хуульд зааснаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хотын хилийн цэсийн хүрээнд цогцоор хөгжүүлж, ашиглалт, үйлчилгээ явуулж, хамгаалах суурин газар нутгийг;

3.1.25.“хотын хил” гэж хуульд зааснаар эрх бүхий байгууллагаас тухайн хотыг цогцоор хөгжүүлж, ашиглалт үйлчилгээ явуулж, хамгаалах нутгийг тогтоосон хил хязгаарыг;

3.1.26.“хот төлөвлөлтийг хязгаарлах бүс” гэж усны сав газар, ой, газар тариалангийн болон хот орчмын барилгажсан газар нутгийг хяналтгүй хөгжлөөс сэргийлэх буюу хотжилтыг хязгаарлах бүсийн нутаг дэвсгэр болон хотын төлөвлөлтөд хөгжүүлэхээр тусгагдаагүй, төлөвлөгдөөгүй газар нутгийг;

3.1.27.“инженерийн судалгаа” гэж газар дэвсгэрийг зохистой болон аюулгүй ашиглахын тулд байгалийн нөхцөл, техногенийн нөлөөллийн үзүүлэлтийг судлах, газар зүйн төлөвлөлт болон архитектурын зураг төсөлд шаардлагатай мэдээ, материал, өгөгдөхүүнийг бэлтгэх үйл ажиллагааг;

3.1.28.“инженерийн бэлтгэл ажил” гэж хот, тосгоны барилга байгууламжийг барьж байгуулахад зориулж тухайн газрын гадаргууд тэгшилгээ хийх, үер, хөрсний нуралт, элсний нүүлт, цасны хунгарлалтаас хамгаалах бэхэлгээ, далан, суваг, гүүрийн байгууламж, гарц, зам, талбай барьж байгуулах урьдчилсан арга хэмжээг;

3.1.29.“инженерийн дэд бүтэц” гэж Барилгын тухай хуулийн 4.1.33-т заасныг;

3.1.30.“нийгмийн дэд бүтэц” гэж соёл, спорт, боловсрол, эрүүл мэнд, худалдаа, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн цогцолборыг;

3.1.31.“хот төлөвлөлтийн суурь судалгаа” гэж хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай тухайн газар нутгийн, хүн ам, эдийн засаг, нийгэм, соёл, зам тээвэр, байгаль орчны ерөнхий үнэлгээ, газар ашиглалтын

болон инженер, геологи, усны хайгуулын үндсэн үзүүлэлт, өгөгдлийг тогтоох үйл ажиллагааг;

3.1.32. “онцгой зохицуулалттай объект” гэж батлан хамгаалах, хил, онцгой байдал, аюулгүй байдал, тагнуулын болон хуулиар онцгой болон стратегийн зориулалттай гэж тогтоосон бусад объектыг;

3.1.33. “барилгажих улаан шугам” гэж одоо байгаа, өөрчлөлт оруулахаар эсхүл шинээр байгуулахаар төлөвлөж байгаа цахилгаан дамжуулах шугам, холбооны, ус хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам зэрэг инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн газар нутгийн хил хязгаарыг харуулсан шугамыг;

3.1.34. “сэргээн засварлах” гэж барилга байгууламж, түүний үндсэн хэсгүүдийн болон инженер-техникийн хангамжийн гол үзүүлэлт (давхрын тоо, өндөр, талбайг хэмжээ, эзлэхүүн, хүчин чадал)-ийн параметр, чанарыг хадгалан авч үлдэж цаашид өвлүүлэн үлдээх зорилгоор бүтнээр буюу хэсэгчлэн сэргээн засварлаж, сайжруулах үйл ажиллагааг;

3.1.35. “болзошгүй арга хэмжээ” гэж үер, газар хөдлөлт, гал түймэр, цөлжилт, хүн, мал, амьтны гаралтай гоц халдварт өвчин, хүн, инженер-техникийн гаралтай онцгой байдал, химийн ба цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, энэ талаар олон нийтэд мэдээлэх, түүнээс хамгаалах арга хэмжээ авах төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг;

3.1.36. “гамшиг” гэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасныг;

3.1.37. “барилгажилтын төсөл гэж” тухайн хот, тосгоны газар нутгийг хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар ашиглалтын бүсчлэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу барилгажуулахад тавигдах төлөвлөлтийн шаардлага бүхий баримт бичгийг;

3.1.38. “хот, тосгоны бүсчлэлийн дүрэм” гэж тухайн хот, тосгоны нутаг дэвсгэрийг төлөвлөлт, үүрэг, зориулалтаар нь энэ хуулийн 25.1-т заасны дагуу бүсчилж, барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, дахин төлөвлөх, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдох үйл ажиллагааг тогтоосноор эрх бүхий байгууллагаас баталсан хот байгуулалтын үе шатны баримт бичгийг дагалдан гарах нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг;

3.1.39. “зөвшөөрөгдсөн газар, талбай” гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны бүсчлэлийн дүрэмд ашиглалтын үүрэг, зориулалт нь тодорхой заагдсан тухайн газар, талбайд хот байгуулалтын үйл ажиллагаа явуулах, барилгажуулахыг.

3.1.40. “Хот байгуулалтын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ” гэж хот байгуулалтын объектын төлөв байдал, тэдгээрийн өөрчлөлтөд ажиглалтыг идэвхтэй орчинд нэгдсэн аргачлалын дагуу зохион байгуулах үйл ажиллагааг.

18.1.1. “бүсийн хөгжлийн төсөл” гэж хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд хэд хэдэн аймгийг хамруулан үйлдвэрлэл, нийгэм, соёл ахуйн үйлчилгээний зохистой хүрээгээр хот, тосгоныг тогтоон бусад бүс нутагтай харилцан уялдаатай харьцангуй бие дааж хөгжих, улсын эдийн засгийн өсөлтийг хангахад голлох үүрэг бүхий бүс нутгийн хөгжлийн баримт бичгийг;

4 дүгээр зүйл. Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1. Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим дараах зарчмыг баримтална:

4.1.1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангах;

4.1.2. хүн амын эрүүл, аюулгүй байдал, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах;

- 4.1.3.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 4.1.4.хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн тэгш эрхийг хангах;
- 4.1.5.ил тод, нээлттэй байх, төрийн болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх;
- 4.1.6.бүс нутаг, хот, тосгоны аюулгүй байдлыг хангах, түүх, соёлын дурсгал, өвийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох, аюулт үзэгдэл, осол гамшгаас урьдчилан сэргийлэх шаардлагыг хангах;
- 4.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах.
- 4.1.8.хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааны залгамж чанар, уялдаа холбоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ, ҮҮРЭГ

5 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

- 5.1.Улсын Их Хурал хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 5.1.1.хот байгуулалтын талаар төрөөс баримтлах бодлогыг батлах;
 - 5.1.2.хот байгуулалтын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 5.1.3.хот, тосгоныг шинээр байгуулах, татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах;
 - 5.1.4.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг батлах, тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 5.1.5.чөлөөт бүс, хилийн боомт, хот, тосгоны хилийн цэсийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

- 6.1.Засгийн газар хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 6.1.1.хот байгуулалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
 - 6.1.2.хот байгуулалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;
 - 6.1.3.хот байгуулалтын тухай хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогыг боловсронгуй болгох санал боловсруулж Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх ;
 - 6.1.4.Улсын Их Хурлаас тодорхойлсон хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улс, бүс нутаг, хот, тосгоны тогтвортой хөгжлийг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах;
 - 6.1.5.бүсийн хөгжлийн төсөл, аймаг, нийслэлийн хөгжлийн төсөл батлах, тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 6.1.6.нийслэл хот, бүсийн хөгжлийн тулгуур төв хот, чөлөөт бүс, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн орд газар болон үйлдвэр, олон улсын чанартай нисэх онгоцны буудлыг даган бий болсон хот, үйлдвэрлэл, технологийн парк, хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах, тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 6.1.7.хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төв хот, чөлөөт бүс, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн орд газар болон үйлдвэр, олон улсын чанартай нисэх онгоцны буудлыг даган бий болсон хот, үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх арга хэмжээний таван жилийн төлөвлөгөөг батлах, тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулах;

6.1.8.аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, онцгой зохицуулалттай барилга байгууламжийн зураг төслийг батлах, тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулах;

6.1.9.онцгой зохицуулалттай барилга байгууламж, түүний нутаг дэвсгэр дэх хот байгуулалтын үйл ажиллагааны журмыг батлах;

6.1.10.бүс нутаг, хот төлөвлөлтийн институтийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах.

7 дугаар зүйл. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.хот байгуулалтын талаарх хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах;

7.1.2.хот байгуулалтын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулах;

7.1.3.хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, техник, технологи, инновацийн бодлогыг тодорхойлж, батлах;

7.1.4.хот байгуулалтын төрийн бодлого, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, нийслэл хот, бүсийн хөгжлийн тулгуур төв хот, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн орд газар болон үйлдвэр, олон улсын чанартай нисэх онгоцны буудлыг даган бий болсон хот, үйлдвэрлэл, технологийн парк, хилийн боомт, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган харилцан уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.5.аж ахуйн нэгж, байгууллагад хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох ажлыг удирдлагаар хангах удирдан чиглүүлэх;

7.1.6.хот байгуулалтын бичиг баримтыг боловсруулах ажлыг зохион байгуулах;

7.1.7.хот байгуулалтын баримт бичигт магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах ажлыг удирдан чиглүүлэх;

7.1.8.салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхтэй холбогдсон бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

7.1.9.аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторыг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн 6 жилийн хугацаагаар томилох;

7.1.10.хот төлөвлөлтийн дараах норм, нормативын баримт бичгийг батлах:

7.1.10.1.хот тосгоны дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар;

7.1.10.2.хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;

7.1.10.3.хот, байгуулалтын баримт бичгийг олон нийтээр хэлэлцүүлэх журам;

7.1.10.4.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, батлах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрэм;

7.1.10.5.хот байгуулалтын баримт бичигт магадлал хийх экспертэд тавигдах шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам;

7.1.10.6.бүс нутгийн хөгжлийн төсөл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар;

7.1.10.7.хот байгуулалтын мэдээллийн сангийн журам;

7.1.10.8.хот байгуулалтын кадастр эрхлэх дүрэм;

7.1.10.9.хот, тосгонд улаан шугам төсөөллөх ба тогтоох заавар;

7.1.10.10.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар;

7.1.10.11.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих дүрэм;

7.1.10.12.аймаг, нийслэлийн Хот байгуулалт, барилга захиалагчийн албаны дүрэм;

7.1.10.13.аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм.

7.1.10.14.хот, тогсоны ногоон байгууламж, автозогсоолын төлөвлөлт боловсруулах дүрэм

7.1.10.15.бусад шаардлагатай норм, нормативын баримт бичиг, дүрэм,

7.2.хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн аймаг, нийслэлийн Хот байгуулалт, барилга захиалагчийн албаны үйл ажиллагааны тухайн жилийн тайлангийн нэгдсэн дүгнэлтийг хэлэлцэж, зөвлөмж гаргах.

8 дугаар зүйл. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

8.1.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу хэрэгжүүлэгч агентлагтай байна.

8.2.Хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

8.3.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, хотод ерөнхий архитектороор удирдуулсан хот байгуулалтын асуудал эрхэлсэн албатай, сум, дүүрэгт мэргэжилтэнтэй байна.

8.4.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.4.1.хот байгуулалтын талаарх хууль, тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах;

8.4.2.дээд шатны байгууллагыг шаардлагатай мэдээлэл, тооцоо, судалгаагаар хангах;

8.4.3.хот байгуулалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, улсын төсөв, орон нутгийн төсвөөс санхүүжих хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах ажлыг зохион байгуулах;

8.4.4.аймаг, нийслэлийн хот байгуулалтын алба, аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

8.4.5.хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичгийг боловсруулах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

8.4.6.хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичиг боловсруулах сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

8.4.7.хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан, түүний цахим сүлжээг бүрдүүлж, байнгын үйл ажиллагааг эрхлэх;

8.4.8.хот байгуулалтын салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан, техник технологи, инновацийн бодлогыг хэрэгжүүлэх;

8.4.9.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хуулийн этгээдэд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох ажлыг зохион байгуулах, эрх эзэмшигчийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

8.4.10. хот байгуулалтын салбарын мэргэжилтнийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

8.4.11.улсын төсөв, орон нутгийн төсвөөр санхүүжих хот байгуулалтын баримт бичгийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

8.4.12.хот байгуулалтын баримт бичигт магадлалын дүгнэлт гаргах иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;

8.4.13.хот байгуулалтын баримт бичигт магадлал хийх ажлыг зохион байгуулах;

8.4.14.хот байгуулалтын баримт бичгийн бүртгэл хөтлөх, хяналт тавих;

8.4.15.хот байгуулалтын норм, нормативын баримт бичгийг сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулах;

8.4.16.салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

8.4.17.хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих;

8.4.18.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үр дүнг жил бүр тайлагнах;

8.4.19.хот, тосгоны хот байгуулалтын бүсчлэлийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

8.4.20.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 5 жилд нэг удаа хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үр дүнг тайлагнах;

8.4.21. аймаг, нийслэлийн Хот байгуулалт, барилга захиалагчийн албаны үйл ажиллагааны тухайн жилийн тайланг нэгтгэн дүгнэж, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа жилийн 01 сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх;

8.4.22.хот төлөвлөлт, хот байгуулалтын талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх

9.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн сум, дүүргийн хөгжлийн төсөл, аймгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу батлах, тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулах;

9.1.2.нийслэл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

9.1.3.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 5 жилийн төлөвлөгөөг батлах;

9.1.4.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдох хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

9.1.5.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, техникийн нөхцөл, газар олголтод хяналт тавьж, Засаг даргын тайланг жил бүр хэлэлцэх;

9.1.6.хот, тосгоны нутаг дэвсгэрийн барилгажилт, нутаг дэвсгэрийн газар ашиглалтын бүсчлэл, түүний хязгаарыг тогтоох;

9.1.7.хот, тосгоны газар ашиглалтын тухайн жилийн төлөвлөгөөг аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын санал авсан үндсэн дээр хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлийн төлөвлөгөөтэй уялдуулан батлах;

9.1.8.хот, тосгоны бүсчлэлийн дүрмийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг бүхий хот, тосгоны захирагчаар удирдуулсан бүсчлэлийн Зөвлөлийг байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавих;

9.1.9.хот, тосгоны бүсчлэлийн дүрмийн хэрэгжилтийн тайланг жил бүр хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлтийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

10 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

10.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, тодотгох, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг санаачлан зохион байгуулах;

10.1.2.нийслэл, бүсийн хөгжлийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 5 жилийн төлөвлөгөөг боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Засгийн газраар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.3.аймгийн зэрэглэлтэй хот болон тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 5 жилийн төлөвлөгөөг хотын Захирагчаас санал авч боловсруулан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.4.хот, тосгоны нутаг дэвсгэрийн барилгажилт, нутаг дэвсгэрийн газар ашиглалтын бүсчлэл, түүний хязгаарыг тодорхойлж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах;

10.1.5.батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг үндэслэн газар олгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.6.хот, тосгоны бүсчлэлийн дүрмийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн үр дүнг бүсчлэлийн Зөвлөлд жил бүр тайлагнах.

11 дүгээр зүйл. Хот, тосгоны Захирагчийн бүрэн эрх, үүрэг

11.1.Хот, тосгоны Захирагч хот байгуулалтын талаар дараах эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төсөл боловсруулахад холбогдох журмын дагуу тухайн хот, тосгоны иргэн, хуулийн этгээдээс санал авах ажлыг зохион байгуулах;

11.1.2.хот, тосгоны бүсчлэлийн асуудлыг хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, хэрэгжилтийг хангах;

11.1.3.аймгийн зэрэглэлтэй Хот, тосгоны захирагч нь хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тогтвортой хөгжлийн бодлого, батлагдсан төлөвлөгөөний дагуу хот, тосгоныг хөгжлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 5 жил тутамд боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах.

11.1.4.улсын зэрэглэлтэй хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 5 жил тутамд боловсруулж, Засгийн газраар батлуулах.

11.1.5.батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

11.1.6.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тайланг 5 жилд нэг удаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж дүгнүүлэх;

11.1.7.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, тодотгох, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг санаачлан зохион байгуулах;

11.1.8.хот, тосгоны бүсчлэлийн дүрмийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлж, хот байгуулалтын мэдээллийн санд тогтмол оруулах;

11.1.9.хот, тосгоны бүсчлэлийн Зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн хүрээнд удирдан зохион байгуулах.

12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн хот байгуулалтын асуудал хариуцсан албаны чиг, үүрэг:

12.1.Аймаг, нийслэлийн хот байгуулалтын барилга-захиалагчийн албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоо, төсвийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр тухайн шатны Засаг дарга Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

12.2.Аймаг, нийслэлийн хот байгуулалтын барилга-захиалагчийн албыг ерөнхий архитектор удирдана.

12.3.Хот байгуулалтын барилга-захиалагчийн алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.3.1.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, барилгажилтын төсөл, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу зохион байгуулах;

12.3.2.хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, барилгажилтын төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

12.3.3.хот байгуулалтын баримт бичгийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих;

12.3.4.аймаг, нийслэлийн дээд шатны удирдлага, байгууллагыг мэргэжлийн арга зүй, мэдээллээр хангах;

12.3.5.хот байгуулалтын мэдээлийн санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, хамгаалах, ашиглуулах ажлыг дүрэм, журмын дагуу тогтмол зохион байгуулах;

12.3.6.хот байгуулалтын баримт бичиг, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэх ажлыг зохион байгуулах;

12.3.7. хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гудамжны нэр, барилгын дугаарыг тогтоож, газрын кадастрын бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах;

12.3.8.барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг, барьж байгуулах ажлын явцад хяналт тавих;

12.3.9.хот байгуулалтын талаар төрөөс баримталж буй бодлого, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний талаар олон нийтэд мэдээллэх;

12.3.10.хот байгуулалтын бодлого, хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг боловсруулахад санал гаргах;

12.4.Аймаг, нийслэлийн хот байгуулалтын, барилга-захиалагчийн алба нь холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийг мөрдөж, эрх, үүргийг мэргэжлийн ёс зүйн хүрээнд хэрэгжүүлнэ.

13 дугаар зүйл. Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын чиг үүрэг

13.1.Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.1.1.хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13.1.2.хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах;

13.1.3.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын зургийн даалгаврыг захиалагчтай зөвшилцөн боловсруулж, батлуулах;

13.1.4.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах архитектур төлөвлөлтийн даалгаврыг захиалагчтай зөвшилцөн боловсруулж, батлах;

13.1.5.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, барилгажилтын төсөл, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулж батлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн дагуу зохион байгуулах;

13.1.6.хот байгуулалт, барилга захиалагчийн албаны үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах;

13.1.7.зураг төсөл, хайгуул, шинжилгээний ажлыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;

13.1.8.инженерийн бэлтгэл ажилд хяналт тавих;

13.1.9.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт, улаан шугамын бүртгэл, зураглалын хөтлөлт, хот байгуулалтын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж, биелэлтийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнах;

13.1.10.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд санал өгөх;

13.1.11.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн барилгажилтын төсөл, барилга байгууламжийн зураг төслийг хянаж батлах;

13.1.12.хот байгуулалт, барилга захиалагчийн албаны үйл ажиллагааны тухайн жилийн тайланг хянаж, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж, дүгнүүлэх;

14 дүгээр зүйл. Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн бусад байгууллагын чиг үүрэг

14.1.Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн бусад байгууллага, дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1.тухайн салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулан боловсруулах, тодотгох, нэмэлт, өөрчлөлт оруулах;

14.1.2.Чөлөөт бүс, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн орд газар, үйлдвэр, олон улсын чанартай нисэх онгоцны буудлыг даган бий болсон хот, аж үйлдвэр, технологийн парк, хилийн боомт, оюутны хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх.

14.1.3. тухайн салбарын хот төлөвлөлт, хот байгуулалттай холбоотой мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сан, хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд тогтмол оруулах.

15 дугаар зүйл. Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд тавих улсын хяналт

15.1.Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах улсын хяналтыг төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

15.2.Төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргээс гадна дараах хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ:

15.2.1.хот байгуулалтын тухай хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтэд;

15.2.2.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд;

15.2.3.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх, батлах үйл ажиллагаанд;

15.2.4.хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилт, түүнтэй холбоотой техникийн нөхцөл, газар олголтод;

15.2.5.инженерийн бэлтгэл ажил, инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламж байгуулах үйл ажиллагаанд.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

16 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичгийн ангилал, тавигдах шаардлага

16.1.Хот байгуулалтын баримт бичгийг нутаг дэвсгэрийг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичиг, хот, тосгоныг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичиг, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гэж ангилна.

16.2.Нутаг дэвсгэрийг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:

16.2.1.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл;

16.2.2.бүсийн хөгжлийн төсөл;

16.2.3.аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

16.2.4.аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн төсөл.

16.2.5. хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

16.3.Хот, тосгоныг хөгжүүлэх төлөвлөлтийн баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:

16.3.1.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

16.3.2.хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;

16.3.3.хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө;

16.3.4.барилгажилтын төсөл;

16.3.5.хот, тосгоныг дахин хөгжүүлэх төсөл;

16.4.Энэ хуулийн 16.2, 16.3-т заасан баримт бичиг нь хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.

16.5.Энэ хуулийн 16.2, 16.3.1-т заасан баримт бичгийн хэрэгжих хугацаа 15-20 жил,

16.6.Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг мөрдөнө.

16.7.Энэ хуулийн 16.2, 16.3.1, 16.3.2, 16.3.6-д заасан хот байгуулалтын баримт бичгийг энэ хуулийн 6.1.10-т заасан хуулийн этгээд боловсруулна.

16.8.Энэ хуулийн 16.3.3-16.3.5, 16.3.6-д заасан хот байгуулалтын баримт бичгийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хот

байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх авсан, сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага боловсруулна.

16.9.Энэ хуулийн 16.2, 16.3.1, 16.3.3, 16.3.6-д заасан хот байгуулалтын баримт бичигт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу байгаль орчны иж бүрэн үнэлгээ хийгдсэн байна.

16.10.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт нь аливаа байгууллага, албан тушаалтны зүй бус нөлөөллөөс ангид байна.

16.11.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах төлөвлөлтийг гүйцэтгэхдээ төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан норм ба дүрэм, журамд заасныг баримтална.

17 дугаар зүйл. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөлд тавигдах шаардлага

17.1.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

17.1.1.Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, эдийн засаг, нийгмийн хөгжлийн загвар, төсөөлөл, газар зүй, цаг уур, байгаль экологи, байгалийн нөөц, дэд бүтэц, хүн ам зүйн бүтэц, түүх, соёлын ястан угсаатны онцлог зэрэг мэдээлэлд үндэслэх;

17.1.2.хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх;

17.1.3.хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээг тодорхойлох;

17.1.4.бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлсэн байх.

17.2.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь хот байгуулалтын суурь баримт бичиг байна.

17.3.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслөөр дараах асуудлыг шийдвэрлэнэ:

17.3.1.хүн амын нутагшилт, суурьшлын одоогийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх;

17.3.2.улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргааны түвшин, байгалийн нөхцөл, нөөц, цаг уурын нөхцөл зэргийг тооцсоны үндсэн дээр хот, хөдөөгийн хүн амын нутагшилт, суурьшилд тохиромжтой нутаг дэвсгэр, бүсүүдийг тогтоох, шинээр бий болох хот, тосгоны газрын байршил, үүргийг тодорхойлох;

17.3.3.улсын хөгжлийг тэтгэх зам, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтцийн үндсэн тэнхлэгийг нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын бодлоготой уялдуулан цогцоор хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

17.3.4.улсын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг оновчтой шийдвэрлэн, хөгжлийн төвүүдийг тодорхойлж, цаашдын хандлагыг тооцон, бүсийн хөгжлийн тулгуур төв, бичил бүсийн төвүүдийн хот, тосгоны оновчтой тогтолцоог тогтоох;

17.3.5.улсын нутаг дэвсгэр, хот, тосгоны дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;

17.3.6.амралт, аялал жуулчлал, байгаль хамгаалал, түүх, соёлын асуудлыг хүн амын нутагшилт, хот байгуулалтын бодлоготой уялдуулан тодорхойлох;

17.3.7.үйлдвэрлэл хөгжих нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хот байгуулалтын нөхцөлийг бүрдүүлэх;

17.3.8.нэг төвөөс олон төвт тогтолцоо руу оновчтой шилжих үндэслэлийг боловсруулах, хөгжлийн ирээдүйн төлөвийг тодорхойлох;

17.3.9.хүн амын нутагшилт, суурьшил, хот байгуулалтын шийдэлд тулгуурласан засаг захиргааны хуваарийг боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлох

17.4.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын болон салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрийн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим, залгамж чанарын уялдаа холбоог хангасан байна.

17.5.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байна.

17.6.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан зааврыг мөрдөнө.

17.7.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд зам тээвэр, эрчим хүч, холбоожуулалтын үндсэн сүлжээг барьж байгуулах ажлыг гүйцэтгэнэ

17.8.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг 5 жил тутамд хийнэ.

17.9.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд энэ хуулийн 17.8-д заасан үнэлгээнд үндэслэн тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

18 дугаар зүйл. Бүсийн хөгжлийн төсөлд тавигдах шаардлага

18.1.Бүсийн хөгжлийн төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

18.1.1.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулатын тухай хуулийн 11.1.1, 12.12 дугаар зүйлд заасан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, бүсийн хөгжлийн хөтөлбөртэй уялдсан байх;

18.1.2.бүс нутгийн нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангахад чиглэсэн эдийн засгийн нэгдмэл орчныг бүрдүүлэх;

18.1.3.хүн амын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, соёл, боловсролын үйлчилгээг тухайн бүс дотор аймаг, орон нутгийн чадавхад түшиглэн цогцолбор байдлаар шийдвэрлэх;

18.1.4.бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, тэдгээрийн бие даан хөгжих боломжийг хангах;

18.1.5.нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг хүндэтгэх, тэдгээрийн онцгой бүрэн эрхэд хамаарах асуудалд хөндлөнгөөс үл оролцох;

18.1.6..эдийн засгийн өсөлтийг хангахад голлох үүрэг бүхий бүс нутгийг түлхүү анхаарч хөгжүүлэх;

18.1.7.тухайн нутаг дэвсгэрт хот байгуулалтын үнэлгээ хийсний үндсэн дээр тус бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсийн хөгжлийн тулгуур төв болон үйлдвэрлэл, нийгэм, соёл ахуйн үйлчилгээний зохистой хүрээгээр хот, тосгоныг тогтоон бусад бүс нутагтай харилцан уялдаатай харьцангуй бие дааж хөгжих;

18.2.Бүсийн хөгжлийн төслийг боловсруулахад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргаанаас төв байгууллагаас баталсан зааврыг мөрдөнө.

18.3.Бүсийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэхдээ эхний ээлжид инженерийн дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүч, холбоожуулалтын үндсэн сүлжээг барьж байгуулна

18.4.Бүсийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэх, хяналт тавих журмыг Засгийн газар батална. /Засгийн газрын бүрэн эрхэд/

19 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөлд тавигдах шаардлага

19.1.Аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:

19.1.1.энэ хуулийн 17, 18, 20, 21 дүгээр зүйлд заасан хот байгуулалтын баримт бичиг, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн талаарх төрөөс баримталж буй бодлоготой уялдсан байх;

19.1.2.аялал жуулчлал, дэд бүтэц, чөлөөт бүсийн талаарх хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт нийцсэн байх;

19.1.3.байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгах;

19.1.4.тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийг дэмжсэн, эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх;

19.2.Аялал жуулчлал, дэд бүтцийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага удирдан зохион байгуулна.

19.3.Аялал жуулчлал, дэд бүтцийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас 5 жил тутамд үнэлгээ хийнэ.

19.4.Аялал жуулчлал, дэд бүтцийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд энэ хуулийн 19.3-д заасан үнэлгээнд үндэслэн тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

20 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум дүүргийн хөгжлийн төсөлд тавигдах шаардлага

20.1.Аймаг, нийслэл, сум дүүргийн хөгжлийн төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

20.1.1.энэ хуулийн 17, 18, 19, 21 дүгээр зүйлд заасан хот байгуулалтын баримт бичигтэй уялдсан байх;

20.1.2.улсын хөгжлийн нэгдсэн бодлого, хөгжлийн баримт бичиг, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт зэрэг баримт бичигт нийцсэн байх;

20.1.3.байгалийн болон инженер-техникийн гаралтай онцгой байдлын нөлөөллөөс нутаг дэвсгэрийг хамгаалах болон иргэний хамгаалалтын арга хэмжээнүүд;

20.1.4.нутаг дэвсгэрийн бүсчлэл болон хот байгуулалтын үйл ажиллагаа явуулахад гарах хязгаарлалт;

20.1.5.тухайн газар нутгийн байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгах;

20.1.6.газар нутгийнхаа хөгжлийн тэнцвэрт байдлыг хангасан, эдийн засгийн, хүн амын ажиллаж амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх;

20.1.7.байгалийн өв газар, түүх, соёлын дурсгалт газрын объектын нутаг дэвсгэрийг сахин хамгаалах арга хэмжээ;

20.1.8.тухайн орон нутгийн онцлого, газар зүйн тогтолцоо зэргийг харгалзан тооцсоны үндсэн дээр үйлдвэрлэлийн ашигтай хувилбаруудыг тооцоолж, хөрөнгө оруулалтын бүс, эдийн засгийн идэвхтэй хөгжлийн нутаг дэвсгэрийг бүрдүүлэх талаарх санал, арга хэмжээг тусгах;

20.2.Аймаг, нийслэл, сум дүүргийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн орон нутгийн засаг захиргааны төв байгууллага удирдан зохион байгуулна.

20.3.Аймаг, нийслэл, сум дүүргийн хөгжлийн төслийн хэрэгжилтийн явцад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас 5 жил тутамд үнэлгээ хийнэ.

20.4. Аймаг, нийслэл, сум дүүргийн хөгжлийн төслийн төсөлд энэ хуулийн 20.3-д заасан үнэлгээнд үндэслэн тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

21 дүгээр зүйл. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тавигдах шаардлага

21.1.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:

21.1.1.энэ хуулийн 17, 18, 19, 20 дугаар зүйлд заасан хот байгуулалтын баримт бичигтэй уялдсан байх;

21.1.2.тухайн нутаг дэвсгэрийн инженер- геологи, гидрогеологи болон байгаль экологи, цаг уур, физик газар зүй, газар хөдлөлийн бичил мужлалын онцлог, хүрээлэн буй орчны нөхцөл, орчны ландшафтын онцлог зэрэг суурь судалгаанд үндэслэсэн байх;

21.1.3.хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн байх;

21.1.4.тухайн хот, тосгоны түүхэн хөгжлийн явцад бүрэлдэн тогтсон хотын архитектур-орон зайн тогтолцооны уламжлал, хүн амын үндэсний зан заншил, байгалийн унаган төрх, өв, түүх, соёлын өвийг хадгалж, хамгаалсан байх;

21.1.5.болзошгүй байгалийн болон инженер-техникийн гамшгийн эрсдлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах инженерийн бэлтгэл арга хэмжээг тооцсон байх;

21.1.6.хот, тосгоны хил хязгаар, газар нутгийн үүргийн бүсчлэл, инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтэц, хүрээлэн буй орчин, архитектур-хот төлөвлөлтийн шаардлага, экологи, эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байх.

21.1.7.хот, тосгоны нутаг дэвсгэрийн зориулалтын бүсчлэлийг оновчтой тогтоосон байх;

21.1.8.усны эх үүсвэр, нөөцийг нарийвчлан тогтоох, саарал ус ашиглах арга хэмжээг тусгах;

21.1.9.тухайн газар нутгийн эко систем, байгаль орчинг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн байх;

21.1.10.инженерийн дэд бүтцийн тогтвортой байдлыг бүрдүүлсэн, эдийн засгийн үр ашигтай, байгаль орчин, хүрээлэн буй орчинд ээлтэй, дэвшилтэд техник, технологийн “ногоон хот”-ын төлөвлөлтийн зарчим, шийдлийг тусгасан байх;

21.1.11.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хамруулсан нийт газар нутгийн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 10-аас доошгүй хувь нь авто зогсоол байх;

21.1.12.Ногоон байгууламж, автозогсоолын төлөвлөлтийг холбогдох норм, нормативын баримт бичгийн дагуу боловсруулна;

21.1.13.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангасан байх.

22 дугаар зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд тавигдах шаардлага

22.1.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 20.1-д заасан шаардлагыг хангасан байна.

23 дугаар зүйл.Онцгой зохицуулалттай барилга байгууламжийн төсөл, барилга байгууламжийн зураг төсөлд тавигдах шаардлага

23.1.Онцгой зохицуулалттай барилга байгууламжийн төсөл, барилга байгууламжийн зураг төсөл нь Барилгын тухай хуулийн холбогдох зүйл, заалтад заасан шаардлагыг хангасан байна.

24 дүгээр зүйл. Хот байгуулалтын баримт бичигт магадлал хийх, даган мөрдөх дүрэм, журам

24.1.Хот байгуулалтын баримт бичигт “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, батлах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрэм”-ийн дагуу тухайн хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын захиалагч нь магадлал хийх ажлыг хариуцна.

24.2.Хот байгуулалтын баримт бичигт магадлал хийх экспертийг сонгон шалгаруулах, эрх олгох үйл ажиллагааг зохион байгуулах, түүний хэрэгжилтийг хангахтай холбогдсон харилцааг “Хот байгуулалтын баримт бичигт магадлал хийх экспертэд тавигдах шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам”-аар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОТ, ТОСГОНЫ НУТАГ ДЭВСГЭРИЙН БҮСЧЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

25 дугаар зүйл. Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэлийн төрөл

25.1.Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэл нь ашиглалт, үүрэг, зориулалтаас хамаарч, дараах төрөлтэй байна:

- 25.1.1.орон сууцны бүс;
- 25.1.2.олон нийтийн бүс;
- 25.1.3.үйлдвэрлэлийн бүс;
- 25.1.4.холимог ашиглалтын бүс;
- 25.1.5.инженерийн дэд бүтцийн бүс;
- 25.1.6.ногоон байгууламж, амралт, аялал, жуулчлалын бүс;
- 25.1.7.хөдөө аж ахуйн бүс;
- 25.1.8.зуслангийн бүс;
- 25.1.9.тусгай зориулалтын бүс;
- 25.1.10.онцгой хамгаалалтын бүс;
- 25.1.11.давхцал бүс;

26 дүгээр зүйл. Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлага, ангилал

26.1.Орон сууцны бүсэд иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг хангасан амины орон сууц, нийтийн зориулалттай орон сууц, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй нийгмийн дэд бүтцийг газар дээрх болон доорх авто зогсоол, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн хамт төлөвлөнө. Орон сууцны бүсэд хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, агаар, ус, хөрс, дуу шуугианы бохирдолгүй жижиг, дунд үйлдвэрийг судалгаа, тооцооны үндсэн дээр төлөвлөж болно.

26.2.Орон сууцны бүсийг дараах байдлаар ангилна:

26.2.1.эдэлбэр газартай амины орон сууцны хороолол, гэр хорооллын дэд бүс;

26.2.2.дундын эзэмшил газартай нам давхрын орон сууцны дэд бүс;

26.2.3.дунд давхрын орон сууцны дэд бүс;

26.2.4.өндөр давхрын орон сууцны дэд бүс.

26.3.Олон нийтийн бүсэд засаг захиргаа, соёл, шинжлэх ухаан, ерөнхий, тусгай, дээд боловсролын, эрүүл мэнд, худалдаа, үйлчилгээ, бизнес, банк санхүүгийн зориулалттай барилга байгууламжийг газар дээрх болон доорх авто зогсоол, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн хамт төлөвлөнө.

26.4.Олон нийтийн бүсийг дараах байдлаар ангилна:

26.4.1.засаг захиргаа, банк санхүү, бизнес үйлчилгээний төв, зочид буудал, үйлчилгээний газрын төлөвлөлтийн дэд бүс;

26.4.2.хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй агаар, ус, хөрс, дуу шуугианы бохирдолгүй жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, арилжааны газрын төлөвлөлтийн дэд бүс.

26.5.Үйлдвэрийн бүсэд хөнгөн, хүнс, хүнд, уул уурхайн, хими, биологи, нано технологийн үйлдвэр, тээвэр, логистик, нийтийн аж ахуй, агуулахын зориулалттай барилга байгууламжийг ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, инженерийн дэд бүтцийн хамт төлөвлөнө.

26.6.Үйлдвэрлэлийн бүсийг дараах байдлаар ангилна:

26.6.1.үйлдвэрийн дэд бүс;

26.6.2.үйлдвэрийн үйл ажиллагааг хангах инженерийн дэд бүтцийн бүс.

26.7.Холимог бүсэд тухайн газар нутгийн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, агаар, ус, хөрс, дуу шуугианы бохирдолгүй жижиг, дунд үйлдвэр, олон нийтийн, орон сууцны барилга байгууламжийг газар дээрх болон доорх авто зогсоол, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн хамт төлөвлөнө.

26.8.Холимог бүсийг дараах байдлаар ангилна:

26.8.1. орон сууц, үйлдвэрийн холимог ашиглалтын дэд бүс;

26.8.2. орон сууц, олон нийтийн холимог ашиглалтын дэд бүс;

26.8.3. олон нийт, үйлдвэрийн холимог ашиглалтын дэд бүс;

26.8.4.орон сууц, олон нийт, үйлдвэрийн холимог ашиглалтын дэд бүс.

26.9.Инженерийн дэд бүтцийн бүсэд авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг төлөвлөнө.

26.10.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүсэд хот орчмын ой, ойн хамгаалах зурвас, амралт, сувилал, олон нийтийн зориулалт бүхий гол, нуурын эргийн зурвас, усан сан, наран шарлагын газар, нийтийн хэрэгцээний ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгжсэн орон зай, талбай, хамгаалалтын ногоон зурвас, биеийн тамир, спортын талбай, тэдгээрийн цогцолбор зэрэг олон нийтийг хамрах амралт, зугаалгын үйл ажиллагааг зохион байгуулахад зориулагдсан орон зайн задгай орчин, түүнчлэн байгалийн дархан цаазат, онцгой хамгаалалттай газар нутгийг төлөвлөнө. /холбогдох хуулиас харах/

26.11.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:

26.11.1.хот орчмын аялал жуулчлалын дэд бүс;

26.11.2.байгаль хамгааллын дэд бүс;

26.11.3.цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн дэд бүс.

26.12.Хөдөө аж ахуйн бүсэд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, хагас эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахианы туслах аж ахуй, зуслангийн аж ахуй, хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, цэцгийн аж ахуйн, хөдөө аж ахуйн зориулалт бүхий барилга байгууламж байрлах, хадлангийн зориулалтаар ашиглах нутаг дэвсгэрийг төлөвлөнө.

26.13.Зуслангийн бүсэд иргэд түр хугацаагаар амьдрах, хот, тосгоноос зайдуу орших дэд бүтцийн хязгаарлагдмал эсхүл бие даасан хангамжтай суурьшлыг төлөвлөнө.

26.14.Тусгай зориулалтын бүсэд инженерийн бэлтгэл ажил, иргэний хамгаалалт, батлан хамгаалах, хорих газар, хатуу, аюултай хог хаягдал, оршуулгын газар, зэрэг бусад бүсэд байршуулах боломжгүй барилга байгууламжийг төлөвлөнө.

26.15.Онцгой хамгаалалтын бүсэд улсын нөөц газар, байгаль хамгаалал, ундны усны эх үүсвэр, шинжлэх ухаан, байгалийн дархан цаазат, тусгай хамгаалалт бүхий нутаг дэвсгэр хамаарна.

26.16.Давхцал бүсэд энэ хуулийн 25.1-д заасан бүсүүдийг дархан цаазат газар, онцгой болон тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын болон бусад газруудтай

давхцуулан эсхүл зөвшилцөн хөгжүүлэхээр төлөвлөгдсөн газар нутаг хамаарна. Тухайн давхцал бүсийн төлөвлөлтөд газар нутгийн газар зүйн онцлог, тогтоц, хүрээлэн буй орчин, түүх, соёлын дурсгалт газрыг хадгалж хамгаалах, тэдгээрийн зохистой газар ашиглалтыг дэмжихэд чиглэсэн төлөвлөлтийн шийдлийг тусгана.

26.17. Давхцал бүсийг дараах байдлаар ангилна:

26.17.1. түүх, дурсгалын хамгаалалт бүхий газар нутгийн давхцал дэд бүс;

26.17.2. зөвшилцөн хөгжүүлэх газар нутгийн давхцал дэд бүс.

26.18. Хот, тосгоны нутаг дэвсгэрт давхцал бүсийг төлөвлөх, хил хязгаарыг тогтоох, давхцал бүсийн зорилго, ашиглалтын горимыг тухайн хот, тосгоны бүсчлэлийн дүрмээр тогтооно.

27 дугаар зүйл. Хот, тосгоны бүсчлэлийн дүрэм, түүнд тавигдах шаардлага

27.1. Тухайн хот, тосгон нь хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу нутаг дэвсгэрийн бүсчлэлийн ашиглалтын хязгаарлалтыг тогтоосон, барилгажилтын үйл ажиллагааг явуулах шаардлагатай нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон бүсчлэлийн дүрэмтэй байна.

27.2. Хот, тосгоны бүсчлэлийн дүрмийг энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан Хот, тосгоны бүсчлэлийн нийтлэг дүрмийн дагуу боловсруулна.

27.3. Хот, тосгоны бүсчлэлийн дүрмийг боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг тусгана.

27.4. Хот, тосгоны бүсчлэлийн дүрмийг батлах, тодотгол хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг энэ хуулийн 9.1.8-д заасан бүсчлэлийн Зөвлөл хэрэгжүүлнэ.

27.5. Хот, тосгоны бүсчлэлийн дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

27.6. Хот, тосгоны бүсчлэлийн дүрмээр хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэл, түүний хил хязгаарыг тогтоох, үндсэн болон дэд бүсүүдийн зорилго, ашиглалтад тавигдах шаардлагыг тодорхойлох, барилга байгууламж, түүний эдэлбэр газрын хувь, хэмжээ, харьцаа, бүсчлэлийн Зөвлөлийн орон тоо, чиг үүргийг тогтооно.

28 дугаар зүйл. Хот, тосгоны бүсчлэлийн нийтлэг дүрэм

28.1. Хот, тосгоны бүсчлэлийн нийтлэг дүрэм дараах шаардлагыг хангасан байна:

28.1.1. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон нутаг дэвсгэрийн үүрэг, зориулалтын бүсчлэлийн төлөвлөлтийн үндсэн зарчмыг баримтлах;

28.1.2. энэ хуулийн 25 дугаар зүйл, 26 дугаар зүйлд заасан бүсчлэлийн төрөл, ангилал, түүнд тавигдах шаардлагыг хангах;

28.1.3. иргэн, хуулийн этгээд, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийн хуульд заасан эрхийг хангах;

28.1.4. хот, тосгоны газрыг үр ашигтай, зохистой ашиглах, газрын эдийн засгийн өгөөж, нөөцийг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжих таатай нөхцөлийг бүрдүүлэх;

28.1.5. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж, хот, тосгоны үндсэн дүр төрхийг бий болгох;

28.1.6. хүрээлэн буй орчин, соёлын өвийг хамгаалах;

28.1.7. хот байгуулалтын бүсчлэлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, тодотгол хийх хугацаа, нөхцөлийг тусгах.

28.1.8.барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал, эзлэхүүн төлөвлөлтөөс хамааран түүний эдэлбэр газрын хэмжээ, зориулалтыг тогтоох;

28.1.9.зөвшөөрөгдсөн газар, талбайн хэмжээг шинээр баригдах, өргөтгөл хийх барилга байгууламжийн хэмжээтэй уялдуулах.

28.2.Хот, тосгоны бүсчлэлийн дүрэм нь дараах бүрдэлтэй байна:

28.2.1.хот, тосгоны бүсчлэлийн дүрмийн бичвэр;

28.2.2.хот, тосгоны бүсчлэлийн дэвсгэр зураг;

28.2.3.хот байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага;

28.2.4.хот, тосгоны бүсчлэлийн асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах үйл ажиллагаа.

28.3.Хот, тосгоны бүсчлэлийн дүрэм, хот, тосгоны бүсчлэлийн дэвсгэр зурагт нэмэлт, өөрчлөлт, тодотгол оруулах хүсэлтийг бүсчлэлийн Зөвлөл тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

29 дүгээр зүйл. Хот байгуулалтын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үе шат

29.1.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын болон салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх төрийн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим, залгамж чанарын уялдаа холбоог хангасан байна.

29.2.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

29.3.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг эрх бүхий байгууллага баталсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газраар батлуулна.

29.4.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, байршлыг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлоор нь салбар бүрээр эрэмблэн үр ашгийн тооцоолол, хариуцан хэрэгжүүлэх хуулийн этгээдийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгана.

29.5.Бүсийн хөгжлийн төслийг Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

29.6.Бүсийн хөгжлийн төслийг эрх бүхий байгууллага баталсан өдрөөс хойш 4 сарын хугацаанд багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ хуулийн 29.4-т заасан арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, Засгийн газраар батлуулна.

29.7.Бүсийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, байршлыг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлоор нь салбар бүрээр эрэмблэн үр ашгийн тооцоолол, хариуцан хэрэгжүүлэх хуулийн этгээдийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгана.

29.8.Аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн дагуу салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

29.9.Аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрх бүхий байгууллага баталсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд багтаан салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тус төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ хуулийн 29.4, 29.7-д заасан арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, Засгийн газраар батлуулна.

29.10.Аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, байршлыг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлоор нь салбар бүрээр эрэмблэн үр ашгийн тооцоолол, хариуцан хэрэгжүүлэх хуулийн этгээдийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгана.

29.11.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

29.12.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн төслийг эрх бүхий байгууллага баталсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд багтаан тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тус төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ хуулийн 29.4, 29.7, 29.10-т заасан арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

29.13.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, байршлыг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлоор нь салбар бүрээр эрэмблэн үр ашгийн тооцоолол, хариуцан хэрэгжүүлэх хуулийн этгээдийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгана.

29.14.Нийслэл, бүсийн хөгжлийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрх бүхий байгууллага баталсан өдрөөс хойш 5 сарын хугацаанд багтаан тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ хуулийн 29.4, 29.7, 29.10, 29.13-т заасан арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, Засгийн газраар батлуулна.

29.15.Аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрх бүхий байгууллага баталсан өдрөөс хойш 5 сарын хугацаанд багтаан тухайн аймаг, сумын Засаг дарга нь тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ хуулийн 29.4, 29.7, 29.10, 29.13-т заасан арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

29.16.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тухайн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөр, инженерийн бэлтгэл ажил, инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтэц, барилга байгууламжийн зураг төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг тооцож, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, байршлыг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлоор нь эрэмблэн үр ашгийн тооцоолол, хариуцан хэрэгжүүлэх хуулийн этгээдийн хамт холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгана.

29.17.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

29.17.1.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ инженерийн бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр ус, цахилгаан, дулаан хангамжийн

найдвартай эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, гол зам, холбоожуулалтын сүлжээнээс эхлэн барьж байгуулах ажлыг хэрэгжүүлж зохицуулах;

29.17.2.орон сууцны хороолол, үйлдвэр, үйлчилгээний цогцолборыг зам, талбай, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, тохижилтын хамт иж бүрэн гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлж зохицуулах;

29.17.3.хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

29.18.Хот, тосгоны орон зайн болон газрын нөөцөд хот, тосгоны тогтоогдсон хилийн цэс доторхи нутаг дэвсгэр, газрын доор болон дээр байрлах инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж багтана.

29.19.Хот, тосгоны эдэлбэр газрыг хот байгуулалтын баримт бичиг, хот байгуулалтын норм, нормативын баримт бичгийн дагуу барилгажуулж ашиглана.

29.20.Хот, тосгоны эдэлбэр газарт барилга байгууламж барих, ашиглах газар доорх, дээрх орон зайн төлөвлөлт, ашиглалтыг хот байгуулалтын норм, нормативын баримт бичгийн дагуу зохицуулна.

29.21.Хот, тосгоны хил хязгаарт багтаж байгаа газар доорх, дээрх орон зай нь тухайн нутгийн захиргааны байгууллагын мэдэлд хамаарагдах бөгөөд дараах орон зайн хэсэг үүнд хамаарахгүй:

29.21.1.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу газар доорх нөөц баялгийн геологийн судалгаа хийх, олборлох үйл ажиллагааны зориулалтаар байгууллага, иргэдэд олгосон газар доорх бусад орон зайн хэсэг;

29.21.2.агаарын тээврийн зориулалтаар ашиглаж буй агаар мандлын орон зайн хэсэг.

29.22.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тухайн хот, тосгоны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээд өмчийн хэлбэрээс үл хамааран дагаж мөрдөнө.

29.23. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жил тутамд хийнэ.

29.24. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд энэ хуулийн 29.23-т заасан үнэлгээнд үндэслэн тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

30 дугаар зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хориглох бүс

30.1.Хот байгуулалтын үйл ажиллагааг дараах бүсэд хориглоно:

30.1.1.түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд;

30.1.2.усны эх үүсвэр, усны сан бүхий газрын эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд;

30.1.3.ашигт малтмалын орд бүхий бүсэд;

30.1.4.байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай бүсэд;

30.1.5.экологийн онцгой болон сүйрлийн бүсэд;

30.1.6.газар дээрх болон доорх дэд бүтэц бүхий бүсэд.

30.2.Хот байгуулалтын үйл ажиллагааг хориглохтой холбоотой журмыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

31 дүгээр зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах бүс

31.1.Хот байгуулалтын үйл ажиллагааг дараах бүсэд хязгаарлана:

31.1.1.инженерийн дэд бүтцийн бүс;

31.1.2.ногоон байгууламж, амралт, аялал, жуулчлалын бүс;

- 31.1.3.хөдөө аж ахуйн бүс;
- 31.1.4.зуслангийн бүс;
- 31.1.5.тусгай зориулалтын бүс
- 31.1.6.давхцал бүсэд.

32 дугаар зүйл. Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хориглох зүйл

32.1.Хот төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах зүйлийг хориглоно:
32.1.1.энэ хуулийн 16,17, 18, 19, 20, 21, 23, 26, 27, 28, 29, 30 дугаар зүйлд заасныг зөрчих;

32.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг;

32.2.Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах зүйлийг хориглоно:

32.1.1.хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний үндсэн шаардлага, үе шатны зорилт, хот байгуулалтын бүсчлэлийн үүрэг зориулалт, инженерийн шугам сүлжээний даац, технологийн горим зөрчиж газар олгох;

32.1.2.техникийн нөхцөлийн зөвшөөрөл, бүрдэлгүй газар олгох;

32.1.3.олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулах;

32.1.4.инженер-геологийн судалгаа, зураг төсөлгүй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барих, өргөтгөх, шинэчлэх;

32.1.5.холбогдох байгууллагаар хянагдаж баталгаажсан хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тэдгээрийг зөрчих, зөвшөөрөлгүй дур мэдэн өөрчлөх;

32.1.6.инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст барилга байгууламж төлөвлөх, барих;

32.1.7.хот байгуулалтын бүсчлэлийн үүрэг зориулалтыг өөрчлөх, зөрчих.

32.2.Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шийдвэрт хамрагдсан тухайн газар нутагт газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох, хот байгуулалтын бусад үйл ажиллагаа явуулахыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдах хүртэл түр зогсооно.

33 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх

33.1.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх үйл ажиллагааг энэ хуулийн 7.1.8.4-д заасан дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.

33.2.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хянах чиг үүрэг бүхий газар, алба, захиалагч, хөрөнгө оруулагчид Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийх дүрмийг баримтлана.

34 дүгээр зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих

34.1. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна энэ хуулийн 7.1.8.11-т заасан дүрмийн дагуу олгож, хяналт тавина.

34.2. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хуулийн этгээдэд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг дараах төрлөөр олгоно:

34.2.1. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

34.2.2. хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө;

34.2.3. барилгажилтын төсөл;

34.2.4. хот, тосгоныг дахин хөгжүүлэх төсөл;

34.3. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг олгох, хүчинтэй байх хугацаа, түүний сунгалтыг “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих журам”-ын дагуу өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.

34.4. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хот байгуулалтын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг дараах тохиолдолд хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ:

34.4.1. энэ хуулийн 7.1.8, 16,17,18,19, 20, 21, 25, 26, 27, 30, 32, 35.1.1, 35.1.6 дугаар зүйл, 41.1.3, 41.1.4, 41.1.7 дугаар хэсэгт тусгагдсаныг зөрчсөн;

34.5. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий хуулийн этгээд нь тухайн жилийн үйл ажиллагааныхаа мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

35 дугаар зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг

35.1. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэн дараах эрх, үүрэгтэй:

35.1.1. хот байгуулалтын тухай хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг мөрдөх;

35.1.2. хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд оролцох;

35.1.3. хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд батлагдсан хот байгуулалтын баримт бичгийг мөрдөх;

35.1.4. хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлд тавигдах шаардлагад нийцүүлэн газар өмчлөх, эзэмших, ашиглах, барилга байгууламж барих, инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн зураг төслийн дагуу гүйцэтгэх;

35.1.5. орчны бохирдлоос сэргийлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангах, дэвшилтэт техник, технологи, инноваци нэвтрүүлэх;

35.1.6. магадлалын нэгдсэн дүгнэлт, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

35.1.7. хот байгуулалтын үйл ажиллагааны сөрөг үр дагаврыг нэн даруй эрх бүхий байгууллагад мэдээллэж, шийдвэрлүүлэх.

36 дугаар зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн бус мэргэжлийн байгууллагын чиг үүрэг

36.1. Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн бус мэргэжлийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

36.1.1.хот байгуулалтын салбарын хүний нөөцийн давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;

36.1.2.хот байгуулалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргах, мэргэжлийн зөвлөмж өгөх;

36.1.3.архитектурын түүхэн дурсгалт газар, улсын болон орон нутгийн соёлын биет өвд, түүний хамгаалалтын бүсэд багтсан газар нутаг, барилга байгууламжийн сэргээн засварлах зураг төсөл, баримт бичиг боловсруулахад тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө өгөх;

36.1.4.хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрэм, журмын дагуу орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг зөвшилцсөний үндсэн дээр байгуулах;

36.1.5.хот байгуулалтын баримт бичгийг орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зөвлөмж гаргах;

36.2.Хот байгуулалтын мэргэжилтний ёс зүйн дүрмийг боловсруулж хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах, хэрэгжилтийг хангах;

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ХУУЛИЙН ЭТГЭЭД, МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГЛЭЛ

37 дугаар зүйл. Бүс нутаг, хот төлөвлөлтийн институт

37.1.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн хөгжил, хот төлөвлөлт, архитектур, хот байгуулалтын мэргэжлийн судалгаа, шинжилгээ, мэдээлэл, зөвлөмжөөр хангах, улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх энэ хуулийн 37.3.1, 37.3.2, 37.3.3-т заасан хот байгуулалтын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий судалгаа, зураг төсөл боловсруулах төрийн өмчит байгууллага байна.

37.2.Энэ хуулийн 37.1 дэх хэсэгт заасан байгууллага нь аймаг, нийслэлд салбар нэгжтэй байж болно.

37.3.Бүс нутаг, хот төлөвлөлтийн институт нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

37.3.1.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүс нутаг, чөлөөт бүс, бүс нутгийн хэмжээний аялал жуулчлал, дэд бүтцийг хөгжүүлэх төсөл, хот байгуулалтын иж бүрэн судалгааг хийх,

37.3.2.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн төсөл боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах;

37.3.3.бүсийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, бүсийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, уул, уурхайн орд газар, томоохон үйлдвэр, нисэх онгоцны буудлыг даган бий болох хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, онцгой зохицуулалттай объектын зураг төсөл боловсруулах;

37.3.4. хот байгуулалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааг боловсронгуй болгох,

холбогдох судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, дэвшилтэт техник, технологи, инноваци нэвтрүүлхэд санал дүгнэлт гаргах;

38 дугаар зүйл. Хот байгуулалтын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжилтэн, мэргэжилтний нийтлэг ёс зүй

38.1. Хот байгуулалтын салбарын мэргэжилтэн энэ хуулийн 8.4.10-т заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд хамрагдана.

38.2. Хот байгуулалтын салбарын ажилтны тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус мэргэжлийн зөвлөл шийдвэрлэнэ.

38.3. Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн дүрэм, мэргэшсэн хот төлөвлөгчийн эрх олгох дүрмийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.4. Хот байгуулалтын салбарын мэргэжилтэн дараах мэргэшлийн зэрэгтэй байна:

38.4.1. хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор;

38.4.2. хот төлөвлөлтийн зөвлөх архитектор.

38.5. Хот байгуулалтын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

38.6. Хот байгуулалтын мэргэжилтний нийтлэг ёс зүй:

38.6.1. нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх;

38.6.2. албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх;

38.6.3. энэ хууль болон бусад хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйн дүрэм, салбарын норм, нормативын хэв хэмжээг даган мөрдөх;

39 дүгээр зүйл. Мэргэшсэн хот төлөвлөгчийн эрхийг сунгах, хүчингүй болгох

39.1. Мэргэшсэн хот төлөвлөгчийн эрхийг энэ хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасан эрх бүхий байгууллагаас баталсан мэргэшсэн хот төлөвлөгчийн эрх олгох дүрэмд заасан журмын дагуу эрх авсан мэргэжилтэнд мэргэшсэн зэргийг 3 жил, зөвлөх зэргийг 5 жилийн хугацаатайгаар тус тус олгоно.

39.2. Мэргэшсэн, зөвлөх зэргийг энэ зүйлийн 39.1-д заасан хугацаагаар тус бүр 2 удаа сунгуулсан тохиолдолд хугацаагүй олгогдсонд тооцно.

39.3. Мэргэшсэн хот төлөвлөгчийн эрхийг орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн шийдвэрээр дараах тохиолдолд хүчингүй болгоно:

39.3.1. нас барсан;

39.3.2. өөрөө татгалзсан;

39.3.3. мэргэшсэн зэрэг олгох горилох сургалтад хүндэтгэн үзэн шалтгаангүйгээр дарааллан хоёр жил хамрагдаагүй;

39.3.4. мэргэшсэн хот төлөвлөгчийн мэргэжлийн ёс зүй, хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон.

39.4. Мэргэшсэн хот төлөвлөгчийн эрх нь хүчингүй болсон этгээд нэг жилийн хугацаанд мэргэшсэн зэрэг горилох сургалтад хамрагдахыг хориглоно.

40 дугаар зүйл. Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн чиг үүрэг

40.1.Энэ хуулийн 36.1.4-т заасан орон тооны бус мэргэжлийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

40.1.1. хот байгуулалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааны үе шатны асуудлыг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, санал дүгнэлт, зөвлөмж гаргах;

40.1.2.мэргэшсэн хот төлөвлөгчийн эрх олгох, мэргэшлийг нь тасралтгүй дээшлүүлэх сургалт зохион байгуулах үйл ажиллагааг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах;

40.1.3.хот байгуулалтын мэргэжилтний ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

40.1.4.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий хуулийн этгээдийг арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах;

41 дүгээр зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий хуулийн этгээд, төрийн бус байгууллага, хот байгуулалтын баримт бичгийн захиалагч, гүйцэтгэгч, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг

41.1.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хуулийн этгээд, төрийн бус байгууллага, хот байгуулалтын баримт бичгийн захиалагч, гүйцэтгэгч, хөрөнгө оруулагч дараах эрх, үүрэгтэй:

41.1.1.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын даалгавар, зургийн даалгаврыг зөвшилцөн боловсруулж, эрх бүхий этгээдээр батлуулах;

41.1.2.хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд орчны бохирдлоос сэргийлэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангах, дэвшилтэт техник, технологи, инноваци нэвтрүүлэх;

41.1.3.хот байгуулалтын баримт бичгийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт нийцүүлэн боловсруулах;

41.1.4.хот байгуулалтын баримт бичгийн магадлалын нэгдсэн дүгнэлтийг хэрэгжүүлэх;

41.1.5.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үе тухайн орон нутгийн иргэд, олон нийт, засаг захиргааны байгууллагын саналыг тусгах, орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурал, шаардлагатай тохиолдолд хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны дэргэдэх шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;

41.1.6.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хуулийн этгээд, хот байгуулалтын баримт бичгийн захиалагч, гүйцэтгэгч, хөрөнгө оруулагч, төрийн бус байгууллага нь хот байгуулалтын тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг мөрдөх;

41.1.7.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хуулийн этгээд, төрийн бус байгууллага хот байгуулалтын мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдөх;

41.1.8.захиалагч, хөрөнгө оруулагч нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулахад хууль бус үйлдэл хийхийг шаардах, энэ чиглэлийн удирдамж, заавар өгөх зэрэг аливаа дарамт шахалт үзүүлэхгүй байх.

42 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичгийн захиалагч

42.1.Хот байгуулалтын баримт бичгийн захиалагч нь дор дурдсан этгээд байна:

42.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөл, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэл, бүсийн тулгуур төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын захиалагч нь хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

42.1.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн төсөл, аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах ажлын захиалагч нь тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны захирагч.

42.2.Хот байгуулалтын баримт бичгийн захиалагч нь хот байгуулалтын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт заасны дагуу магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулна.

42.3.Архивын тухай хуулийн дагуу хот байгуулалтын баримт бичгийн бүрдлийг архивт шилжүүлж хадгална.

43 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах гадаадын иргэн, хуулийн этгээд

43.1.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хүсэлт гаргасан гадаадын иргэн мэргэжлээрээ ажилласан туршлагатай, хууль тогтоомжийн дагуу ажиллах зөвшөөрөлтэй байна.

43.2.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хүсэлт гаргасан гадаадын хуулийн этгээд энэ хуульд заасан хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхтэй байна.

43.3.Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий гадаадын иргэн, хуулийн этгээд нь энэ хуульд заасан эрх бүхий Монгол Улсын хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хот байгуулалтын баримт бичиг боловсруулна.

43.4.Гадаадын иргэн, хуулийн этгээд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх авах хүсэлтэд тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр эрхийн баримт бичгийг хавсаргана.

43.5. Хот байгуулалтын салбарт үйл ажиллагаа эрхлэх гадаадын хуулийн этгээд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9-д заасны дагуу бүртгүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

44 дүгээр зүйл. Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо

44.1.Хот төлөвлөлтийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод хүргэх, хот байгуулалтын баримт боловсруулах, төлөвлөлтийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангасан байна.

44.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хот, тосгоны захирагч нь хот төлөвлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 7.1.8.3-т заасан журмын дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, оновчтой саналуудыг тусгана.

44.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хот, тосгоны захирагч нь хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах тов, байршлыг тогтоох, нийтэд зарлах, хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангах, хэлэлцүүлэг явуулах, хэлэлцүүлгээс гарсан саналыг тэмдэглэх, нэгтгэх, үр дүнг танилцуулах, хэлэлцүүлгээс гарах шийдвэрийг хот байгуулалтын баримт бичиг боловсруулах хуулийн этгээд, захиалагч тус бүрт хүргүүлэх ажлыг холбогдох журамд заасны дагуу зохион байгуулна.

44.4.Хэлэлцүүлгийн товыг тогтоож, олон нийтэд зарласны дараа товыг зайлшгүй өөрчлөх шаардлага гарсан нөхцөлд тухайн хэлэлцүүлгийн шинэчлэсэн товыг олон нийтэд зарласан арга хэрэгслээр дахин зарлана.

44.5.Албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэлэлцүүлэгт ирээгүй нь хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

44.6.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хот, тосгоны захирагчийн ажлын алба нь хэлэлцүүлгийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар шийдвэр гарснаас хойшхи 7-оос доошгүй хоногийн хугацаанд олон нийтэд мэдээлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТР, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, ТҮҮНИЙГ ЭРХЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

45 дугаар зүйл. Хот байгуулалтын кадастр

45.1.Хот байгуулалтын кадастр нь хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх, газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл бүхий улсын сан мөн.

45.2.Хот байгуулалтын кадастрыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хот, тосгонд эрхэлнэ.

45.3.Газрын кадастр нь хот байгуулалтын кадастрын суурь болох бөгөөд өөрийн үйл ажиллагаатай холбоотой бусад салбарын кадастрын мэдээллийг агуулна.

45.4.Хот байгуулалтын кадастр улсын хэмжээнд нэгдсэн системтэй байна.

45.5.Хот байгуулалтын кадастр нь газар нутгийн хөгжлийн болон хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын баримт бичиг болох бөгөөд түүнд дараах мэдээлэл хамаарна:

45.5.1.геодези, байр зүй, зурагзүйн материал;

45.5.2.газар нутгийн экологи, инженер-геологи, газар хөдлөлтийн мэдээлэл;

45.5.3.гидрогеологийн мэдээлэл;

45.5.4.хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, барилгажилтын талаарх мэдээлэл;

45.5.5.инженерийн бэлтгэл ажил, инженерийн дэд бүтэц, нийгмийн дэд бүтэц, олон нийтийн барилга байгууламж, тохижилтын талаарх мэдээлэл.

45.6.Хот байгуулалтын кадастрын мэдээлэл нь хот байгуулалт баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үндэс болно.

45.7.Хот байгуулалтын кадастрын мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

45.8.Энэ хуулийн 45.7-д заасан асуудалтай холбогдсон зөрүүтэй мэдээлэл түгээснээс үүсэх хохирлыг уг мэдээллийг түгээсэн этгээд хариуцна.

45.9.Хот байгуулалтын кадастрыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

46 дугаар зүйл. Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сан, түүний иж бүрдэл, агуулга, мэдээлэл солилцоо, хөтлөлт, хөгжүүлэлт, тэдгээрийг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын чиг үүрэг

46.1.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, аймаг, нийслэлийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглах, иргэдийг нэг эх үүсвэрээс үнэн, зөв мэдээллээр хангах зорилгоор хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сантай байна.

46.2.Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэлд боловсруулалт хийх, хадгалах, хамгаалах, ашиглуулахтай холбогдсон үйл ажиллагааг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлж хөтөлнө.

46.3. Аймаг, нийслэлийн мэдээллийн нэгдсэн санг тухайн аймаг, нийслэлийн хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хот, тосгон тус бүрээр бүрдүүлэн хөтөлнө.

46.4. Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу зохицуулагдана.

46.5. Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нууцад хамаарахаас бусад мэдээлэл нийтэд нээлттэй байна.

46.6. Хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сан нь Орон зайн өгөгдөлийн дэд бүтцийн сангийн дэд сан байх бөгөөд нэгдсэн нэг программ хангамжийг ашиглана.

46.7. Хот байгуулалтын мэдээллийн сангийн иж бүрдэл, агуулга, мэдээлэл солилцоо, хөтлөлт, хөгжүүлэлтийг дараах этгээд хариуцна:

46.7.1. улсын хэмжээнд хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сангийн иж бүрдэл, агуулга, мэдээлэл солилцоо, хөтлөлт, хөгжүүлэлт, хадгалалт, засвар, сэргээлт, аюулгүй байдлыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

46.7.2. аймаг, нийслэлийн хэмжээнд хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл солилцоо, хөтлөлт, хадгалалт, аюулгүй байдлыг аймаг, нийслэлийн хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

47 дугаар зүйл. Онцгой байдал буюу байгалийн давагдашгүй хүчин зүйл, осол, гамшгийн үеийн хот байгуулалтын үйл ажиллагааны зохицуулалт

47.1. Онцгой байдал буюу байгалийн давагдашгүй хүчин зүйл, осол, гамшгийн үеийн болон алан хядах үйл ажиллагаа, нийтийг хамарсан халдварт өвчний үед авах арга хэмжээг тусгайлсан хуулиар зохицуулна.

47.2. Хот байгуулалтын үйл ажиллагааны хүрээнд эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр үер, хөрсний нуралт, элсний нүүлт, цасны хунгарлалт, гал түймэр, газар хөдлөлт, цөлжилт, хүн, мал, амьтны гаралтай гоц халдварт өвчин, хүн, инженер-техникийн болон химийн ба цацрагийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх зэрэг гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, энэ талаар олон нийтэд мэдээллэх, түүнээс хамгаалах арга хэмжээ авах төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ тус тус хамаарна.

47.3. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, албан тушаалтан нь дараах хяналт, мониторингийг хэрэгжүүлнэ:

47.3.1. хот байгуулалтын үйл ажиллагааны үр дүн, хүн амын ажиллаж, амьдрах эрүүл, аюулгүй орчны стандарт, хэм хэмжээ /агаар, ус, хөрс, тоос, дуу шуугиан, цахилгаан соронзон долгион г.м/- ний хангалт;

47.3.2. инженерийн дэд бүтцийн үйлчилгээ, нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ, ногоон байгууламжийн хүртээмж, замын хөдөлгөөний аюулгүй байдал;

47.3.3. эрүүл ахуй, аюулгүйн хамгаалалтын бүсийн стандартын хэрэгжилт;

47.3.4. олон нийтийн оролцооны талаарх хөндлөнгийн хяналт, мониторинг.

48 дугаар зүйл. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын санхүүжилт

48.1. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлыг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

48.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэл болон бүсийн хөгжлийн тулгуур төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн суурь судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвөөс;

48.1.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн төсөл, аймгийн төв, нийслэл хот орчмын бүсийн дагуул хот, аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн суурь судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг орон нутгийн төсвөөс.

48.2.Энэ хуульд заасан бусад баримт бичиг боловсруулах ажлыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагч байгууллага, иргэдээс санхүүжүүлж болно.

48.3.Хот байгуулалтын норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах, сурталчлах ажлын зардлыг Барилгын тухай хуулийн 5.5-д заасан Барилга байгууламжийн норм, нормативын сангаас санхүүжүүлнэ.

48.4.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын төсөвт өртгөөс 0.18 хувиар авсан орлого нь Барилгын тухай хуулийн 5.7-д заасан Барилга байгууламжийн норм, нормативын сангийн эх үүсвэрт хамаарна.

47 дугаар зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагааны санхүүжилт

47.1.Хот байгуулалтын үйл ажиллагааны санхүүжилт нь улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаас бүрдэнэ.

47.2.Хот байгуулалтын үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг хот байгуулалтын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Төсвийн тухай хуулийн дагуу тооцон тогтоож санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

48 дугаар зүйл.Хот байгуулалтад зориулсан бонд

48.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, улс, орон нутгийн төсөвт тусгагдаагүй хот байгуулалтын үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг гаргах зорилгоор хот байгуулалтын бондыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гаргаж болно.

48.2.Хот байгуулалтын бондын хүүгийн хувь, хэмжээ, гаргах арга хэлбэр, гаргах явц, эргэн төлөлтийг зохицуулсан журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

49 дүгээр зүйл. Хот байгуулалтын үйл ажиллагаанд хийх хяналт, шинжилгээ, үнэлгээ

49.1.Хот байгуулалтын үйл ажиллагаанд хийх хяналт, шинжилгээг хот байгуулалтын баримт бичигт хийгдэх хяналт шинжилгээний хамт 2 жил тутамд хийнэ.

49.2.Хот байгуулалтын үйл ажиллагааны объектын хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнг улсын хот байгуулалтын кадастр, хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

49.3.Хот байгуулалтын үйл ажиллагаанд тавих хяналт, шинжилгээг улсын хэмжээнд хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд аймаг, нийслэл, хотын Хот байгуулалт, барилга захиалагчийн алба хариуцна.

49.4.Улсын хэмжээнд хийгдсэн хот байгуулалтын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газарт, аймаг, нийслэлийн хэмжээнд хийгдсэн

хот байгуулалтын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулна.

49.5.Хяналт, шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тодотгол, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцна.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗЙЛ

50 дугаар зүйл. Гомдол, маргааныг шийдвэрлэх

50.1.Хот байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг харьяалах төрийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагад гаргана.

50.2.Гомдлыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

50.3.Энэхүү хуультай холбоотой гомдол гаргах, хянан шийдвэрлэх асуудлыг Захиргааны ерөнхий хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зохицуулна.

51 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчидөд хүлээлгэх хариуцлага

51.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51.2.Энэ хуулийн 7.1.8, 9.1.6, 16.7, 16.8, 21.1.2, 25, 26, 27.5, 28, 29.22, 30, 31, 32, 35.1.1, 35.1.2, 35.1.4, 35.1.6, 38.6.1, 38.6.2, 38.6.3, 39.4, 41.1.1, 41.1.4, 41.1.6, 41.1.7, 41.1.8,42.2, 43.1, 43.2, 43.3, дугаар зүйлийг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

51.3.Хот байгуулалтын баримт бичиг нь энэ хууль болон бусад хуульд заасан тусгай шаардлагыг хангаагүй тохиолдолд түүнийг буцаах үндэслэл болно.

51.4.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий хуулийн этгээд хуульд заасан шаардлага хангаагүй хот байгуулалтын баримт бичиг боловсруулсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг 3 жилийн хугацаатайгаар цуцална.

51.5.Хот байгуулалтын баримт бичгийн магадлын дүгнэлтийг хууль зөрчиж гаргасан экспертийн магадлал хийх эрхийг 2 жилийн хугацаатайгаар цуцална.

51.6.Энэ хуулийн 7.1.8, 9.1.7, 10.1.5, 11.1.5, 13.1.11, 27.5, 28, 30, 31, 33, 34.2, 38.6.1, 38.6.2, 38.6.3 зүйлд заасныг зөрчиж, хот байгуулалтын баримт бичгийг баталсан төрийн эрх бүхий байгууллагын эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах үндэслэл болно.

51.7.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51.8.Хот байгуулалтын тухай хууль зөрчигчидөд торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

51.9.Хот байгуулалтын тухай хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, хот байгуулалтын баримт бичгийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд шийтгэл ногдуулна.

51.10.Хот байгуулалтын тухай хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, хот байгуулалтын баримт бичгийг зөрчсөн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас нь огцруулах үндэслэл болно.

52 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

52.1.Энэ хуулийг 20.... оны ... сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

DRAFT